Хольцыг жигд хурдаар явж, температурын горимыг баримтлан тасралтгүй дэвсэнэ. Хэрэв дэвсэлтийн явцад аль нэг хэсэгт зузаан, налуу алдагдах, нүх хонхор үүсэх, дэвссэн гадаргуу арзгар болох, бруссын сайн халаагүйгээс мөр үүсэх зэрэг дутагдал гарвал дэвсэлтийг нэн даруй зогсоож, гарсан алдааг Инженерийн шаардлагад нийцэхээр бүрэн засварлана. Инженер зөвшөөрсөний дараа дэвсэлтийг үргэлжлүүлнэ. Гүйцэтгэгч асфальтобетоны ажлыг бүхэлд нь хариуцсан чадварлаг мэргэжилтэнг томилон ажиллуулах бөгөөд тэр нь дэвсэлт, нягтруулалтын болон заводын үйл ажиллагааг хооронд нь нягт уялдуулан зохион байгуулах ёстой. Дэвсэлтийг хийхдээ дэвсэгчийг ойр ойрхон зогсоохгүйгээр жигд явуулах ба хучилтын хөндлөн залгаасыг аль болох цөөн гаргахаар ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Хэрэв дэвсэгчийн автомат хянах систем эвдрэх эсвэл буруу ажиллах тохиолдолд ажлын ердийн өдрийн үлдсэн хугацаанд гараар удирдаж ажиллуулж болно.

Хэрэв Гүйцэтгэгч гадаргуун тэгш байдал болон налууг шаардлагын хэмжээнд хүртэл гаргаж чадаагүй бол Инженерийн зөвшөөрөх хэмжээнд хүртэл гадаргууг дахин засварлаж, тоног төхөөрөмжийг засварлах буюу өөр тоног төхөөрөмжөөр солих арга хэмжээ автал хучилтын ажлыг түр зогсооно. Хольцыг дэвсэх явцад чанарын шаардлага хангаагүй (шатсан, битум ихэдсэн, дутуу холигдсон, бага температуртай г.м) хольц ирвэл дэвсэгчид хүлээн авахгүйгээр талбайгаас шууд зайлуулж хаяна.

Дэвсэгчийг ашиглах боломжгүй жижиг талбайд хольцыг гараар дэвсэхийг зөвшөөрнө. Гэхдээ гараар хийсэн дэвсэлтийн чанарыг Гүйцэтгэгч бүрэн хариуцах ба хэрэв ямар нэгэн ажил шаардлагад нийцээгүй бол түүнийг зайлуулж, оронд нь шинээр хийхийг Инженер зааварчилж болно. Дахин хийсэн ажлын зардлыг Гүйцэтгэгч хариуцна. Өгсүүр хэсэгт дэвсэлт хийх үед хучилтын доогуур ус орохоос хамгаалсан арга хэмжээ авна.

 <p>Хот төлөвлөлт, судалгааны институт</p>	УЛААНБААТАР ХОТ, ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТӨЙРӨӨС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ								
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА			Масштаб: М1:500		
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор				Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Гүйцэтгэгч	<i>Э.Өнөнөнх</i>	Э.Өнөнөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24			А3	8	18
ЭТ 19-507/10	Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-			2024 он		

ХОЛЬЦЫГ НЯГТРУУЛАХ

Асфальт хольцыг дэвссэний дараа нэн даруй сайтар жигд индүүдэж нягтруулна. Хольцыг индүүдэж эхлэх үеийн хольцны температур 130°C-аас багагүй байна. Дэвсэлт болон нягтруулалтыг хийдээ техникийн шаардлагыг мөрдлөгө болгон ажиллах ба 90°C-аас багагүй температуртай байхад нягтруулалтын ажлыг дуусгах шаардлагатай

Индүүний төрөл, жин, тоо ширхэг нь хольцыг тохиромжтой температуртай үед нь нягтруулахад шаардлагатай нягт авахад бүрэн хангалттай байх ёстой. Ашиглах тоног төхөөрөмж болон нягтруулах ажилбарын дараалал болон явалтын тоог Гүйцэтгэгч талбайн туршилтаар баталж үзүүлэн, Инженерээр зөвшөөрүүлсэн байх ёстой. Дор дурьдсан ерөнхий зарчимд заасанчлан үеийг шаардлагатай нягт авах хүртэл индүүднэ.

Нягтруулах ажил эхлэхээс өмнө ажиллах индүүнүүдийн түлшний системийг сайтар шалгаж, хэрэв түлш дусах юмуу гоожиж байвал засаж янзалсан байна. Мөн булны услалтын системийг шалгаж тохируулсан байх хэрэгтэй.

Эхний нягтруулалтыг 6-8тн жинтэй, ган бултай доргиурт индүүгээр дэвсэгч машины араас аль болох ойр зайд дагаж хийнэ. Дэвсэлтийн чиглэлд эхлээд хийх явалт бүрт доргиулагчийг ажиллуулахгүй, харин буцах явалт бүрийг доргиулагчтай хийнэ.

Дараагийн шатанд 12-16тн жинтэй хийн дугуйт индүүгээр нягтруулалтыг хийж сүүлчийн нягтруулалтыг хүнд жинтэй 3 булт индүүгээр индүүдэж түрүүчийн индүүний мөрийг дарна. Бүх индүү нь араараа ухарч ажиллах бөгөөд (өөрөөр хэлбэл индүүний хөтлөгч дугуй буюу бул нь дэвсэгчийн талд байрлалтай байна) цагт 5 км-ээс илүүгүй жигд хурдаар ажиллана.

Нягтруулалтыг хучилтын гадаад ирмэгээс эхэлж тэнхлэгийн шугам руу чиглэсэн байдлаар, индүүний явалт бүр урьд явсан мөрний хагасыг дарах маягаар хийнэ. Эргэцтэй хэсэгт хэвгийн нам талаас өндөр тал руу чиглэсэн байдлаар гүйцэтгэнэ. Индүүний хөдөлгөөний чиглэл нь замын тэнхлэгтэй аль болох паралель байхаар нягтруулалтыг хийх ба ялангуяа нэг, хоёрдугаар индүүдлэгийн үед огцом эргэж хажуу тийш шилжих, ташуу байдлаар явахыг хойглоно.

Хучилтын захыг индүүдэх явцад индүүний дугуй дэвсэлтийн ирмэгээс 50-100 мм илүү гарч байх ёстой.

Нягтралаа бүрэн аваагүй хучилт дээр индүү болон бусад техник зогсоож болохгүй, хэрэв ажлын явцад индүү эвдрэх буюу өөр шалтгаанаар зогсох бол түүнийг нягтарсан хэсэгт эсвэл талбайн гадна яаралтай гаргах арга хэмжээ авна. Нягтруулалт хийж буй индүүнүүд түр зогсохоор бол урьд нь нягтарсан хэсэгт шилжиж зогсоно.

Асфальтобетон хучилтын нягтыг Төслийн Чанарын хяналтын төлөвлөгөөнд заасан давтамжаар, үеийн нийт зузаанаар авсан хос дээжийн дундаж нягтаас тооцон гаргана. Ингэхдээ асфальтобетоны ажил хийгдсэн өдөр тутамд 1-ээс доошгүй хос дээж авна.

Асфальтобетон хучилтын нягт нь заасан нягттай ижил буюу түүнээс их байх ба дараалсан 10 туршилтаас 2-с илүүгүй тохиолдолд нягт нь заасан нягтаас 2-оос дээш хувиар доогуур байж болно.

Нягтруулсан үеийн хамгийн бага, шаардагдах нягтрал нь батлагдсан орцын нормын дагуу нягтруулсан. Маршаллын загварын нягтралын 98%-тай тэнцэх ёстой. Нягтралын хэмжээ нь тогтоосон стандартад хэмжээнд хүрээгүй гадаргууг дахин нягтруулж нягтралыг нь дараачийн өрөмдлөгөөр тодорхойлно

ӨНГӨЛГӨӨ, ИРМЭГ БА ЗААДАС

Аливаа хольц хагарах, хог шороотой холилдож суларч гарах тохиолдолд түүнийг ухан авч шинэ халуун хольцоор дүүргэн эргэн тойрны гадаргуутай ижил хэмжээнд нягтруулна.

Өмнө нь хийгдсэн хучилттай залгаж дараагийн хэсгийг дэвсэхдээ урьд дэвссэн үеийг нийт өргөн ба гүнд нь шулуун шугамаар зүсэгч машин ашиглан хөндлөн зүснэ. Гар багаж (лоом, сүх г.м) ашиглаж болохгүй. Зүсэлт хийсэн босоо нүүрийг хийн халаагуураар халааж 130/200 маркийн халуун битум түрхэх ба үүний дараа нэн даруй шинэ хольцоо залгаж дэвсэнэ. Дэвсэлтийг эхлэхдээ дэвсэгчийн өнгөлөх хавтан нь зүсэлтийн шугамнаас хойш 20-30см илүү гарсан байхаар дэвсэгчийг байрлуулна.

Дэвсэгчийг явуулж эхлэхээс өмнө шнекээр татагдаж ирсэн халуун хольцыг залгаасны хэсгийн хуучин хучилт дээр 5-10 минут орчим байлгаад үүний дараа дэвсэгчийг ажиллуулна. Залгаасны хэсэгт дэвсэгч явж өнгөрмөгц овон товон дэвсэгдсэн хольцыг малтуураар жигд хусч аваад залгаасан дээрээ нарийн ширхэглэлтэй хольц цацаж гараа маш нямбай тэгшлэнэ. Тэгшилгээ сайн болсон гэж үзвэл индүүдлэгийг шууд эхлэнэ.

Залгаасны өнгөлгөөг гадаргууд тавигдах шаардлагын дагуу хучилтын бусад хэсэг дэх нягтрал, бүтэц, өнгөлгөө зэрэгтэй ижил байхаар хийж гүйцэтгэнэ.

Хэрэв дэвсэлтийн явцад гадаргууд чулууны ялгарал үүсч барзгар болсон бол халуун хольцоноос авч нарийн нүхтэй шүүрээр тухайн хэсэг дээр шигшээд дараа нь модон малтуураар хөнгөн гүйлгэж сайтар тэгшлээд индүүднэ


АСФАЛЬТОБЕТОНООС ДЭЭЖ АВАХ БА ШИНЖЛЭХ

Гүйцэтгэгч нь MNS AASHTO T168:2003 (Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн асфальтобетон хольцоос дээж авах) стандарт, бүлэг 209(Д)-д заасан давтамжаар дээж авч, туршилтыг явуулна.

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ШИНЖИЛГЭЭНҮҮД

Битумэн хольцыг холих ба дэвсэх үед Гүйцэтгэгч түүний Төслийн чанарын хяналтын төлөвлөгөө болон Техникийн шаардлагын Хэсэг 200, Зүйл 1229-ын дагуу хольц болон түүний бүрэлдэхүүн материалудаас дээж авч шинжилж байх ёстой. Хэрвээ шинжилгээний үр дүн материалын шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч материал болон ажлын журамд оруулах шаардлагатай өөрчлөлтийг хийхээс өмнө Инженерийн зөвшөөрлийг авсан байх ёстой.

Хэрвээ хольц болон материалын 10 амжилттай шинжилгээ тутамд хоёроос дээш тооны шинжилгээний хариу нь Шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч шалтгааныг нь олж тогтоож залруултал хольц дэвсэхийг даруй зогсооно. Гүйцэтгэгч шаардлага хангахгүй байгаа бүх материалыг өөрийн зардлаар буцаан авч шаардлага хангах материалаар хучилтын нийт өргөнөөр солино.

 <p>Хот төлөвлөлт, судалгааны институт</p>	УЛААНБААТАР ХОТ, ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ								
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА			Масштаб: М1:500		
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор				Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24			А3	9	18
ЭТ 19-507/10	Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-			2024 он		

ХҮЛЦЭХ АЛДАА

Гүйцэтгэгч хучилтыг Техникийн шаардлагын 300-р бүлэгт заасан геометр хүлцэх алдааны хүрээнд барина. Гүйцэтгэгч хольцын найрлагыг жишиг орцын норм болон талбайн туршилтуудаар тодорхойлсоны дагуу Хүснэгт 10-5-д үзүүлсэн хүлцэх алдааны хүрээнд байлгана.

Хүснэгт 10-5: Асфальтобетон хольцны хүлцэх алдаа

Бүрэлдэхүүн хэсэг	Хүлцэх алдаа
Битумын агуулга	Хольцны нийт жингийн $\pm 0.3\%$
4.75 мм ба түүнээс том шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 6\%$
2.36 - 0.15 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 4\%$
0,075 мм-ийн шигшүүрээр өнгөрөх хувь	Эрдэс нунтгийг оролцуулан хуурай чулуулаг материалын нийт жингийн $\pm 2\%$
Хольцны температур	$\pm 10\text{ }^\circ\text{C}$

Нэг удаагийн шинжилгээгээр гарсан битумын агууламжийг хольцийн нийт жингээр үржүүлж тооцсон, аливаа үеийн нийт уртад орох битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой. Хольцын жинг шалгаж тодорхойлсон өдөр тутам үйлдвэрлэсэн хольцын битумын дундаж хэмжээ нь заасан хэмжээнээс багагүй байх ёстой.

1000 м урт хэсэгт хоорондоо ижил зайтай 6 цэгт хэмжсэн асфальтобетон хучилтын өргөн зурагт заасан өргөнөөс бага байж болохгүй. Аль ч цэгт замын тэнхлэгээс хучилтын гадаргуугийн ирмэг хүртэл зай заасан зайнаас 10 мм-ээс илүү нарийссан байж болохгүй

ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, БАЙГАЛИЙН ЧУЛУУН ХАВТАН

БҮЛГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэ бүлэгт явган хүний зам, талбайд зориулсан явган хүний замын хавтангийн геометр хэмжээсийн хүлцэх алдаа, хавтанг өрж суулгах ажлыг хамруулсан болно.

1. ТОДОРХОЙЛОЛТ

Авто замын дагуух замын хашлаганаас барилга байгууламжийн нүүр хүртэл зайг явган хүний зорчих чөлөө гэнэ. Зөвхөн хүн зорчиход зориулсан явган хүний зорчих чөлөөний нэг хэсгийг явган хүний зам гэнэ.

Явган хүн - явганаар хүүхдийн тэрэг, чарга чирч яваа хүн 35см-ээс бага голч бүхий унадаг дугуйтай хүн, роликтой хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэлнэ.

Явган хүний зам - явган зорчигчийн хөдөлгөөнд зориулсан, ногоон байгууламж тохижилтын бүс ба барилга байгууламжийн нүүр хэсэг хоёрын хооронд байрласан явган хүний зорчих чөлөөний хэсэг

Хөндлөн налуу - явган хүний замын хөндлөн хэвгийг хэлнэ.


Налуу хавтан ба хашлага - явган замаас автомашины замруу орох гарах хөдөлгөөнийг саадгүй байлгах зорилгоор замын хашлагыг налуулж суулгасан замын хавтан ба хашлага.

Налуу хавтангийн дээд хэсэг - налуугаар суулгасан хавтангийн дээд хэсэг хүртлэх зурвасын газрын өргөн.

Барилга байгууламжийн нүүр хэсэг - гудамжны үйлчилгээ, дэлгүүр, лангуу, кафе зэрэгт зориулсан, явган хүний зам болон барилга байгууламжийн нүүр хэсэг хоёрын хооронд байгууламжийг тусгаарласан явган хүний зорчих чөлөөний хэсэг.

Ногоон байгууламж - явган хүний тав тухыг хангах хэрэгсэл болох сандал, автобусны буудал саравч, галын унтараагуур, замын гэрэлтүүлэгийн шон болон бусад зориулалтын шон мод, зүлэг зэргийг байрлуулсан замын хашлага ба явган замын хоорондох явган хүний зорчих чөлөөний хэсэг.

Замын хашлага - явган хүний зам, ногоон байгууламжийг автомашины замаас тусгаарласан явган хүний зорчих чөлөөний хэсэг

 Хот төлөвлөлт, судалгааны институт ЭТ 19-507/10	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Масштаб: М1:500		
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА	Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор		А3	10	18
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24	2024 он		
Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-...				

ЯВГАН ХҮНИЙ ЗАМД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Явган хүний замын хавтан нь MNS 5682-2006, MNS 4699-99 “Явган зам, талбайн хавтан” стандартын шаардлагыг хангасан байх. Явган хүний замын хучилтын суурийн материал нь MNS D 1241-2002 стандартын шаардлага хангасан, далангийн дээд үеийн хуурай үеийн хамгийн их нягт 90%-иас их, суурийн 95%-иас дээш байна.

Явган хүний замын хавтан жигд өнгөтэй байх бөгөөд бетон хавтангийн чулуу нь ил гараагүй, завсаргүй, тэгш байхаас гадна явган зорчигчийг хальтрахаас хамгаалсан хамгаалалттай байна. Явган хүний замын хавтанг барилгын ажилд ашиглахаас өмнө үйлдвэрлэгчийн сертификатыг ТИ-т танилцуулж, зөвшөөрөл авсан байна.

Явган хүний замд ашиглах хавтангийн геометр хэмжээс нь Хүснэгт 17-1-д заасан хүлцэх алдааны дотор байна.

Хүснэгт 17-1. Явган хүний замын хавтангийн хүлцэх алдаа /мм/

Төрөл	Хүлцэх алдаа /мм/
Урт, өргөн	± 2.0
Зузаан	± 2.0
Зузааны зөрүү	≤ 2.0
Гадаргуугийн тэгш байдал	≤ 1.0
Хажуу хананы босоо налуугийн зөрүү	≤ 1.0

Явган хүний замын зорчих чөлөө нь замын хашлага, ногоон байгууламж/тохижилтын хэсэг, явган хүний зам, барилга байгууламжийн нүүр хэсгээс тогтох бөгөөд тэдгээрийн өргөн 17-2 хүснэгтэд заасан хэмжээнээс бага байж болохгүй

Хүснэгт 17-2. Хамгийн бага өргөн

Хэсгийн нэр	Хамгийн бага өргөн, мм
Замын хашлага	80/152
Ногоон байгууламж/тохижилтын хэсэг	610
Явган хүний зам	1500
Барилга байгууламжийн нүүр хэсэг	760
Явган хүний зорчих чөлөөний өргөн	3100
*-MNS 842-2006 стандарт зааснаас багагүй байна	

Налуу - Явган хүний замын дагуу налуу нь 5%-иас хэтрэхгүй байх бөгөөд хэрэв тогтоосон хэмжээнээс хэтэрсэн бол тодорхой зайд налуу хэсэг хийж өгөх нь зүйтэй. Авто замтай огтлолцож буй явган хүний замыг автозамын зорчих хэсгийн түвшинтэй ижил болгохын тулд уусгалттайгаар налуу хийж өгнө

ЯВГАН ХҮНИЙ ЗАМЫН ХАВТАНГ СУУЛГАХ

Явган хүний замыг доор үзүүлсэн схемийн дагуу суурилуулна.



<p>Хот төлөвлөлт, судалгааны институт ЭТ 19-507/10</p>	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТӨЙРӨӨС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Техникийн шаардлага			Масштаб: М1:500			
	Хэлтс. дарга	С. Анхбаяр	Инженер	Г. Болор	ЕГ шифр: ХТСИ - 10/24	Үе шат	Хуудас	Бүх хуудас			
	Гүйцэтгэсэн	Э.Өнөмөнх	Шалгасан	С. Анхбаяр		ТГ шифр: ...-...	А3	11	18		
									2024 он		

**УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТӨЙРӨӨС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ**

Явган хүний замын хавтанг суулгахаас өмнө хэмжилт хийж, 5~10м тутамд хяналтын цэг байгуулан, дөрвөлжин тор татаж, өндөр болон чигийг тогтоосон байна. Явган хүний замд үзүүлэх ачааллын төрлөөс хамрааруулан хавтанг төрөл бүрийн суурин дээр хийнэ.

Зам дээр явган зорчигч явах эсвэл тэргэнцэртэй зорчигч явахад хальтарч бүдрэхгүй, хэв гажилтанд орохгүй, хөдөлгөөнд орохгүй бат бөх суурьлуулахад сайтар анхаарна.

Боломжтой тохиолдолд хальтиргаа эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор термопластик материалаар нэмэлт давхарга хийж болно.

Чулуун хучлага нь төвшингийн зөрүүг бий болговол, хараа болон хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд тээглэх, унах эрсдэлийг бий болгодог тул тэгш суулгахад сайтар анхаарах

Явган замын зэрэгцээ хоёр хавтангийн хооронд босоо чиглэлд өөрчлөлт гарахыг төвшингийн өөрчлөлт гэдэг. Иймээс инженерийн зөвшөөрөлөөр төвшингийн өөрчлөлтийг засаж залруулах арга хэмжээг яаралтай авах ёстой.

1. Төвшингийн өөрчлөлт 6.0-13мм байх тохиолдолд гадаргууг өөлж, огтлох замаар 5% налуутай болтол засна

2. Төвшингийн өөрчлөлт 13мм байх тохиолдолд түүнийг налуу болгох, эсвэл зайлуулах, солих арга хэмжээ авна

А. Элсэн дэвсгэр үе дээр явган хүний зам барих

Явган хүний зам болон талбайд ирэх ачаалал харьцангуй бага тохиолдолд явган хүний замын чулуун ба бетон хавтанг элсэн дэвсгэр үе дээр суулгах ба дараах аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

- Суурийг бэлтгэх

Урьдчилсан бэлтгэсэн талбайд элс-цементны холимогийг зурагт заасан зузаантайгаар дэвсэж, элс цементны холимогийг зохих багаж хэрэгслийн тусламжтайгаар, налуу ба түвшинг хангах хэмжээнд сайтар тарааж тэгшилнэ. Тэгшилсэн үеийг 1м²-д 10л-ээс доошгүй усыг жигд цацаж услан, гар доргиулагчаар сайтар нягтруулна.

- Явган хүний замын хашлага суулгах

Хашлаганы суурийн нүхийг зохих өргөн, гүнд ухаж нягтруулан, ажлын зурагт заасан маркийн бетон зуурмаг ашиглан дэвсгэр үе хийж, хашлагыг нэг талаас нь эхлэн суурилуулж, ар хананы манаасыг хийнэ.

- Явган хүний замын хавтанг суулгах

Бэлэн болон суурь дээр ажлын зурагт тусгасан хэмжээ, схемийн дагуу чулуун ба бетон хавтанг хооронд нь 2-3мм зайтайгаар өрөх ба чулуун ба бетон хавтанг сайтар суулган, зэрэгцээ гадаргуугийн тэгш байдлыг хангахын тулд тохиромжтой багажаар хэрэгсэлээр тогтвортой суулгах эсвэл резин алхаар зөөлөн тоншиж тэгшилнэ. Суулгаж тоншиж байх үедээ хавтангийн ирмэг буланг гэмтэхээс сэргийлнэ. Шаардлагатай тохиолдолд цөөн тооны чулуун болон бетон хавтанг нямбай хуулж аваад доор нь элс нэмж, хасах замаар түвшинг тааруулан тэгш байдлыг хангана. Ингэхдээ явган хүний замын налууг тэгш усаар ойр ойрхон шалгана.

- Завсар зайг дүүргэх

Хавтангийн хоорондох зайг шигшсэн элсээр дүүргэх ба үстэй шүүрээр тал тал тийш нь шүүрдэн тараах байдлаар дүүргэнэ. Гадаргуу дээр үлдсэн элснийг усаар зөөлөн шүршиж туух байдлаар цэвэрлэх бөгөөд заадасны хооронд дүүргэсэн элс угаагдахаас сэргийлэх хэрэгтэй.

А. Хуурай хольц бүхий буталсан чулуун суурин дээр явган хүний зам барих

Бага зэргийн ачаалалтай явган хүний замд болон хөнгөн тэрэгний зогсоолд чулуун ба бетон хавтанг хуурай хольц бүхий буталсан чулуун суурин дээр өрж, суулгах ба дараах аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

- Суурийг бэлтгэх

Урьдчилан бэлтгэсэн талбай ба хайрцганд хуурай хольц бүхий буталсан чулууг зурагт заасан хэмжээ, зузаантайгаар дэвсэж, тохирох багаж хэрэгслийн тусламжтайгаар, зохих налуу ба түвшинг хангах хэмжээнд сайтар тарааж тэгшилнэ. Тэгшилсэн суурийг гар нягтруулагч, бага оврын индүү зэргийг ашиглан сайтар 95%-д хүртэл нягтруулна.

- Явган хүний замын хашлага суулгах


Хашлаганы суурийн нүхийг зохих өргөн, гүнд ухаж нягтруулан, ажлын зурагт заасан маркийн бетон зуурмаг ашиглан дэвсгэр үе хийж, хашлагыг нэг талаас нь эхлэн суурилуулж, ар хананы манаасыг хийнэ.

- Явган хүний замын хавтанг суулгах

Бэлэн болсон буталсан чулуун суурин дээр элс-цементийн хуурай хольцыг 50-100мм зузаантайгаар тарааж дэвсэн, ажлын зурагт заасан хэмжээ, схемийн дагуу чулуу ба цутгамал хавтанг хооронд нь 2-3мм зайтайгаар өрж суулган, зэрэгцээ гадаргуугийн тэгш байдлыг хангахын тулд резин алхаар зөөлөн тоншиж тэгшилнэ. Шаардлагатай тохиолдолд цөөн тооны чулууг болон бетон хавтанг нямбай хуулж аваад доор нь элс нэмж, хасах замаар түвшинг тааруулна. Явган хүний замын налууг тэгш усаар ойр ойрхон шалгана.

- Завсар зайг дүүргэх

Хавтангийн хоорондох зайг шигшсэн элс-цементийн хуурай хольцоор бөглөх ба ингэхдээ түүнийг үстэй шүүрээр тал тал тийш нь шүүрдэн тараах байдлаар дүүргэнэ. Гадаргууг усаар шүршиж цэвэрлэх ба харин энэ үед заадасны хооронд дүүргэсэн хольцыг угааж урсгахгүй байх ёстой. Бүх зай завсар бүрэн бөгөөд нийт гүндээ сайн дүүргэгдсэн байхын зэрэгцээ зуурмаг бүрэн бэхжиж хатуурахаас өмнө шинээр тавьсан явган хүний замын гадаргууг сайтар цэвэрлэж, зуурмагын ул мөр, үлдэгдэл хогийг сайтар цэвэрлэнэ. Явган замын гадаргуун тэгш байдлыг 3 метрийн рейкээр 20м тутамд шалгана 3метрийн рейк доорх зай 3мм-с хэтрэхгүй байна.

 <p>Хот төлөвлөлт, судалгааны институт</p>	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТӨЙРӨӨС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Масштаб: М1:500		
	Хэлтс. дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА		Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Инженер	Г. Болор	ЕГ шифр: ХТСИ - 10/24		А3	12	18
	Гүйцэтгэсэн	Э.Өнөмөнх	ТГ шифр: ...-...		2024 он		
ЭТ 19-507/10	Шалгасан	С. Анхбаяр					

С. Бетон суурин дээр явган хүний зам барих

Дунд зэргийн ба түүнээс дээш ачаалалтай явган замд чулуун ба бетон хавтанг бетон суурин дээр өрж суулгах ба ажлуудыг дараах аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Суурийг бэлтгэх

Бэлэн болсон гадаргуу дээр бетон суурь цутгах хэсгийн өргөнөөр ТИ-ийн зөвшөөрсөн хэв хашмалыг угсарч, 600-1000мм эсвэл зурагт заасан гүн, хэмжээгээр тухайн зайнд гадас зоож бэхлэнэ. Хэрэв арматурын тор хэрэглэх бол 30мм зузаантай тэгшилгээний бетон урьдчилан цутгаж, дээр нь тороо байрлуулна.

Суурийн бетоныг 50-150 мм зузаантай тарааж тэгшлэнэ. Том хэмжээтэй талбайд цутгалт хийхдээ 3000мм тутамд 5мм өргөнтэй температурын заадас хийх ба заадсыг ТИ-ийн зөвшөөрсөн материалаар дүүргэнэ.

- Явган хүний замын хашлага суулгах

Замын хашлагыг зохих түвшинд бетон суурин дээр суулгаж, арын манаасыг зургийн дагуу шаардлага хангасан хэмжээнд хүртэл хийнэ.

- Явган хүний замын хавтанг суулгах

Ажлын зургийн дагуу болон ТИ өөрөөр заагаагүй бол 10-30мм зузаан элсэн үе дээр чулуун ба бетон хавтанг ажлын зурагт тусгасан схемийн дагуу, хооронд нь 2-3мм зайтайгаар суулгана.

- Завсар зайг дүүргэх

Хоорондын зайг элс-цементэн хольцоор дүүргэж, талбайг нийтэд нь усалж, гар доргиулагчаар нягтруулна. Энэ ажиллагааг Инженерэс зааварчилсан хугацаанд дахин давтан гүйцэтгэнэ.

БУСАД ЗҮЙЛ

Барилгын ажлын явцад барьсан явган хүний замын хавтан дээр зуурмаг зуурах, буулгахыг хатуу хориглоно.


Явган хүний замын хавтанг суулгах ажил дууссаны дараагаар элс цементийн хольцоор завсар зайг дүүргэсэн тохиолдолд 3-аас доошгүй хоног ус цацаж арчлах шаардлагатай. Энэ хугацаанд явган зам дээр ямар нэгэн ачаалал өгөхийг хориглоно.

ХҮЛЦЭХ АЛДАА

Явган хүний замын хавтанг тэгш, хөдөлгөөнгүй суурилуулсан байх шаардлагатай бөгөөд бусад инженерийн байгууламжтай ижил түвшинд холбогдсон байх ба ус цугларах, тогтох байдал үүсэхээргүй байна. Явган хүний замын барилгын ажил нь Хүснэгт 17-2-т заасан хүлцэх алдааны дотор байна.

Хүснэгт 17-2. Явган хүний замын барилгын үеийн хүлцэх алдаа

Төрөл	Хүлцэх алдаа /мм/	Шалгах давтамж		Шалгах арга
		Хамрах хүрээ /м/	Тоо	
Тэгш байдал	≤ 5	20	1	3 метрийн рейкээр шалгах
Зэрэгцээ хоёр хавтангийн өндрийн зөрүү	≤ 2	20	1	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр+* авна.
Хөндлөн налууг хэмжих	±2%	20	1	Нивелээр хэмжинэ.
Дагуу залгаасын тэгш байдал	≤ 8	20	1	20метрийн утгай утас татаж хамгийн их үзүүлэлтийг авах
Хөндлөн залгаасын тэгш байдал	≤ 5	20	1	20метрийн утгай утас татаж хамгийн их үзүүлэлтийг авах
Зай завсрын өргөн /том хавтан/	≤ 3	20	1	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна.
Зай завсрын өргөн /жижиг хавтан/	≤ 2	20	1	Шугаман метрээр хэмжиж, хамгийн их үзүүлэлтээр авна.

 Хот төлөвлөлт, судалгааны институт ЭТ 19-507/10	УЛААНБААТАР ХОТ, ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Масштаб: М1:500		
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА	Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор		А3	13	18
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24	2024 он		
Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-...				

БАЙГАЛИЙН ЧУЛУУН ХУЧИЛТ

Энэхүү бүлэгт Байгалийн чулуун хучилтын хийх аргачлалтын тухай тусгав. Байгалийн чулуу нь өнгө хэлбэр хэмжээгээрээ харилцан адилгүй учир нэгдсэн дүр төрхтэй зам талбай хийх нь ажилчнаас нилээд ур чадвар шаарддаг.

1709 МАТЕРИАЛ

Чулууны хэмжээ зурагт заасан хэмжээс бүхий, дөрвөлжин эсвэл шоо хэлбэртэй чулуу байна. Мөн чулууг өрөх явцдаа хэлбэрт оруулан засах шаардлагатай.

1710 СУУРЬ ҮЕ

Чулуун хучилттай зам нь чулуунуудын хооронд тодорхой хэмжээний заагтай хийгддэг ба энэ заагаар гадаргуугийн усны нэг хэсэг доод суурь руу нэвтэрдэг.

Гадаргуугийн ус нь суурь шингэснээр хөлдөлт овойх аюултай учраас суурийн дор хөлдлөлтөнд тэсвэртэй шүүрүүлэх хайрган үе хийх шаардлагатай. Хайрган үеийн дээр чулууг суулгах дэвсгэр үе хийдэг ба энэ үе нь холбоосгүй элсээр болон нарийн ширхэглэлтэй хайргаар хийгдсэн байвал зохино.

Хэрэв дэвсгэр үе нь 3-5см зузаантай байх ба усыг тогтоохгүй шүүрүүлж байх үүднээс нарийн шаварлаг ширхэглэл нь 6%-иас хэтрэхгүй, хайрганы хамгийн том ширхэглэл нь 8мм -ээс ихгүй байвал зохино. Дэвсгэр үеийг сайтар тэгшилж нягтруулсан байх ба энэ нь хучилтын тэгш байдлыг хангана.

Дэвсгэр үеийн материалыг жигд дэвсэж, нягтруулсаны дараа тэгшлүүр шугамаар татаж тэгшилнэ. Ингэхийн тулд тэгшлүүр шугамыг замын хашлага дагуулан татна. Үүний тулд хашлагыг тэгш суулгасан байх шаардлагатай.


Чулуун хучилтын доорхи буталсан чулуун суурь үе нь төслийн техникийн шаардлагыг хангаж байх шаардлагатай.

БАРИЛГЫН АЖЛЫН ЕРӨНХИЙ ДАРААЛАЛ

Элсэн дэвсгэр үеийг татаж тэгшилж бэлдсэний дараа чулууг хашлагаас замын төв рүү чиглэлтэй суулгана. Нарийн замын хувьд 5-6 үе буюу талбайд бол 1-1,5 м2 болгон чиг болон төвшин, өнцгийг хянаж байх хэрэгтэй. Чигийг хянахын тулд чиг утас татна.

Худгийн таг, замын ус зайлуулах шуудууны тор зэрэг үл хөдлөх зүйлийн хажууд чулууг суулгахдаа бүтэн чулууг хүрээ хийж, дараа нь зүсвэр оруулж болно. Чулууг дэвсгэрт суулгасны дараа завсрыг элс болон нарийн ширхэглэлтэй хайргаар сул дүүргэх ба энэ нь дараагийн чигжих үед хоорондоо үрэлцэж ирмэг нь хагарахаас сэргийлнэ. Чулууг суулгаж завсрыг дүүргэсний дараа цохих болон чичиргээт индүүгээр дахин чигждэг ба энэ үед дэвсгэр үе нягтарч хэмжээ нь багасдаг. Чулуун хучилтыг суулгаж чигжсэний дараа нарийн элсээр засварыг нэмж дүүргэнэ.

Чулуун хучилтын шулуун өргийн гол зарчим нь чулуунуудыг аль болох талаас нь багагүй хэмжээгээр зөрүүлэн завсар гаргалгүй ам дарж, тэгш гадаргуутайгаар өрөх юм. Тухайн ажилбар нь зөвхөн үүгээр хягаарлагдахгүй бөгөөд ажил гүйцэтгэх аргачлалыг Инженерээр баталгаажуулсан байх шаардлагатай.

 <p>Хот төлөвлөлт, судалгааны институт</p>	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Масштаб: М1:500		
	Хэлтс. дарга	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА		Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Инженер	Г. Болор	ЕГ шифр: ХТСИ - 10/24		А3	14	18
	Гүйцэтгэсэн	Э.Өнөмөнх	ТГ шифр: ...-...		2024 он		
ЭТ 19-507/10	Шалгасан	С. Анхбаяр					

**ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Замын тэмдэглэгээ нь Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол MNS 4759:2014 стандартын дагуу хийгдэнэ. Замын тэмдэглэгээний хэмжээ, хэлбэр дүрс нь зурагт үзүүлсний дагуу, эсвэл Инженерийн зааврын дагуу байна. Замын тэмдэглэгээний байршлыг Инженерийн заавраар тогтооно.

Тэмдэглэгээний өнгө нь тод цагаан, зарим хэсэгт шар байна. Замын тэмдэглэгээний халуунаар дэвсэх гэрэл ойлгогч пластик материал нь AASHTO M249 стандартын шаардлагын дагуу байна. Будганд ашигладаг тунгалаг лак нь AASHTO M247 стандартын шаардлагын дагуу байна.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Дараах тоног төхөөрөмжийг хэрэглэнэ. Үүнд:

- Замын гадаргууг цэвэрлэх механик ажиллагаатай шүүр,
- Механикжсан тунгалаг лак шүршигч бүхий замын тэмдэглэгээ хийх механик төхөөрөмж.

Замын тэмдэглэгээ болон тунгалаг лагыг зөвхөн механик аргаар тавина. Замын тэмдэглэгээний төхөөрөмж нь нэгэн жигд хэмжээ, зузаантай дэвсэх чадвартай байна. Эдгээр машинууд нь гадаргуу дээр тогтоосон хүлцэх алдааны хязгаарт тэгш ирмэгтэй, урсалт, барзгар болон үсэргээгүй жигд өргөнтэй шугам тавих чадвартай байна. Замын тэмдэглэгээ хийх төхөөрөмжийн цагаан шугам тавих өргөнийг тохируулах боломжтой байх ба 5км/цаг-аас багагүй хурдаар ажилладаг байх ёстой. Халуун пластик материалыг 3.2-4.8 мм-ийн зузаантайгаар механик аргаар тавина. Үсэг, цифр, тэмдгүүдийг хэв шаблон ашиглан зам дээр тэмдэглэнэ.

ГАДАРГУУГИЙН БЭЛТГЭЛ

Тэмдэглэгээ тавих гадаргууг усалж, шүүрдэн, хийн даралтаар шаардлагатай хэмжээнд хүртэл нийтэд нь цэвэрлэнэ. Тэмдэглэгээ тавьж эхлэхээс өмнө хучлагын гадаргуу нь цэвэрхэн, хуурай ба шороо, тоос, тос, бензин болон бусад хортой бодисоор бохирдоогүй байна

ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ УЛААН ШУГАМ ТАВИХ

Үсэг, цифр, тэмдэг, шугам тавих байршлыг урьдчилан тогтоохдоо замын тэмдэглэгээтэй ижил өнгийн будгаар 10 мм-ийн голчтой цэгүүд тавьж тэмдэглэнэ. Энэ цэгүүдийн хоорондох зай нь замын тэмдэглэгээг нягт нямбай хийхэд хангалттай, гэхдээ ямар ч тохиолдолд 1.5 м-ээс илүү байж болохгүй. Өөр төрлийн шугамын эхлэл болон төгсгөлийг хучлага дээр тэмдэглэсэн байна.

Бусад тэмдэглэгээний байршил болон хэлбэр дүрсийг хучлагын гадаргуу дээр шохойгоор тавина. Замын тэмдэглэгээний тавигдсан улаан шугамыг Инженерээр шалгуулж зөвшөөрөл авсны дараа тэмдэглэгээний ажлыг эхэлнэ.

Замын гэрэл ойлгогч гэж (будган түрхэц, хуулга, хуудас, нимгэн үе) - Уян хатан, мөргөхөд тэсвэртэй, уян харимхай шинж чанартай, замын хөдөлгөөнийг зохицуулах хэрэгслүүдэд холбох, хадах, түрхэх, наах зориулалтай ойлгох материалыг хэлнэ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯЗГААРЛАЛТ

Дараах нөхцөлүүдэд Гүйцэтгэгч замын тэмдэглэгээний ажлыг зогсооно. Үүнд:

- Хучлагын гадаргуу чийгтэй, агаарын харьцангуй чийгшил 80%-иас их;
- Агаарын температур 10°C-аас доош;

Салхины хурд нь замын тэмдэглэгээний ажилд сөргөөр нөлөөлөх.


ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ

Халуун пластик материалаар үсэг, цифр, тэмдэг, үргэлжилсэн ба тасархай шугамыг зурагт үзүүлсний дагуу, эсвэл Инженерийн зааварчилгааны дагуу тавина. Пластик материалыг хайлуулж, тунгалаг лактай хамт гадаргуу дээр механик аргаар, нэг үеэр тавина. Тэмдэглэгээний машиныг хэрэглэхээс өмнө Гүйцэтгэгч нь тухайн машин нь Техникийн шаардлагын дагуу ажиллах хүчин чадалтайг нотолно. Хэрэв ямар нэгэн тохиргоо хийх шаардлагатай болбол Гүйцэтгэгч нь машинд зохих тохиргоог хийж, эцсийн үр дүн батлагдах хүртэл талбайн туршилтыг дахин хийж гүйцэтгэнэ.

Шаардлагатай гэж үзвэл өдөр бүр хучлагын тэмдэглэгээ дэвсэх орц хэмжээг шалгаж, тохируулна. Пластик материалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу хадгалж, бэлтгэнэ. Замын тэмдэглэгээний будгийг дэвсэх орц, хэмжээ нь будах талбайг 3.2 мм-ээс багагүй зузаантайгаар, зогсолтгүй будахад хангалттай байх ёстой. Дэвсэх орц, хэмжээ нь замын гадаргуугийн бүтцээс хамааран өөрчлөгдөж болох ба үүнийг Инженер талбайн туршилт хийх үеэр тогтооно.

ТУНГАЛАГ ЛАКААР БУДАХ

Гүйцэтгэгч нь замын тэмдэглэгээний материалыг тавьсан даруйдаа тэмдэглэгээний машины нэг хэсэг болох шүршигчээр тунгалаг лагыг үргэлжилсэн ажиллагаагаар шүршинэ. Тунгалаг лагыг өөрийн жингийн хүчээр шүршдэг машиныг ашиглаж болохгүй. Тунгалаг лагыг пластик материалд 0.35кг/м2 ногдох хэмжээгээр буюу Инженерийн зааварчилсан хэмжээгээр тавина.

 Хот төлөвлөлт, судалгааны институт ЭТ 19-507/10	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ТУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД УУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН УУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ							
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА			Масштаб: М1:500	
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор	ЕГ шифр: ХТСИ - 10/24	Үе шат	Хуудас	Бүх хуудас	
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ТГ шифр: ...-...	А3	15	18	
	Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр				2024 он	

(ё) Хэвтээ тэмдэглэгээг шалгах үзүүлэлт Хүснэгт 15-1

ХҮЛЦЭХ АЛДАА

Замын хөдөлгөөний тэмдэглэгээг дараах хүлцэх алдааны хэмжээнд нягт нарийн тохируулан хийж гүйцэтгэнэ.

(a) Өргөн

Цагаан шугам ба бусад тэмдэглэгээний өргөн нь заасан өргөнөөс 5%-аас илүү өргөн байж болохгүй.

(b) Байршил

Үсэг, цифр, тэмдэг, шугамуудын байршил нь зурагт үзүүлснээс эсвэл Инженерийн зааварчилснаас 20мм-ээс илүү зөрж болохгүй.

(c) Чиглэл

Замын тэнхлэгтэй параллель тавигдах аливаа шугамын ирмэг нь зурагт үзүүлснээс эсвэл Инженер (хяналтын инженер буюу хяналтын зөвлөх багийн ахлагч)-ийн зааварчилснаас 15 м тутамд 10 мм-ээс илүү гажиж болохгүй.

(d) Тасархай шугам

Замын тэнхлэгтэй параллель тавигдах тасархай шугамын урт нь зурагт үзүүлсэн эсвэл Инженерийн зааварчилснаас 150 мм-ээс илүү зөрүүтэй байж болохгүй.

(e) Эргэлт дээрх цагаан шугам

Эргэлт дээрх тасархай болон үргэлжилсэн шугамыг хөвч хэлбэрээр бус зөв арк хэлбэрээр, түүнээс 20 мм-ээс илүү гажилтгүйгээр тавина.


(ё) Хэвтээ тэмдэглэгээг шалгах үзүүлэлт . Хүснэгт 15-1

ТЭЭВРИЙН ХӨДӨЛГӨӨНӨӨС ХАМГААЛАХ

Хучлагын тэмдэглэгээний гэрэл ойлгогч пластик материал гүйцэд хатгал нь тээврийн хөдөлгөөнөөс хамгаална. Гүйцэтгэгч бүх шаардлагатай анхааруулах тэмдэг, хаалт, конус, самбар болон бусад хамгаалалтын хэрэгслүүдийг байрлуулах ба бусад шаардлагатай арга хэмжээг авна.

ЧАНАРГҮЙ АЖИЛ БА МАТЕРИАЛ

Суурилуулсан шилэн гэрэл ойлгогч нь үйлдвэрлэгчээс тодорхойлсон үзүүлэлт болон Инженерийн шаардлагын хэмжээнд гэрэл ойлгохгүй байгаа нь батлагдсан, мөн зураг төслийн зөвшөөрөгдсөн хэмжээнд хийгдээгүй тохиолдолд Гүйцэтгэгч өөрийн зардлаар дахин хийж хяналтын багт хүлээлгэн өгнө.

 Хот төлөвлөлт, судалгааны институт ЗТ 19-507/10	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД УУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН УУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ				Масштаб: М1:500			
	Хэлтс. дарга	<i>C. Анхбаяр</i>	C. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА		Үе шат	Хуудас	Бүх хуудас
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор	ЕГ шифр: ХТСИ - 10/24		А3	16	18
	Гүйцэтгэсэн	<i>Э.Өнөмөнх</i>	Э.Өнөмөнх	ТГ шифр: ...-...		2024 он		
Шалгасан	<i>C. Анхбаяр</i>	C. Анхбаяр						

УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД УУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН УУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ

ЗАМЫН БАЙНГЫН ТЭМДГҮҮД

Харин авто замын дагуух км-ийн заалт, өгсүүр уруу, тахир огцом эргэлт зэрэг газарт анхааруулах зорилгоор шонд суурьлуулсан байнгын тэмдгүүдийг байрлуулна.

Гүйцэтгэгч энэхүү зүйлийн ажлыг ажлын зурагт өгөгдсөний дагуу хийж гүйцэтгэнэ. Хэрэв Инженерээс өөрөөр зааварчлаагүй бол замын бүх тэмдгүүд нь MNS 4597 : 2014 стандартын дагуу үйлдвэрлэгдэж, MNS 4596:2014 ын дагуу тавигдсан байна. Гүйцэтгэгч нь Инженерийн зөвшөөрсөн үйлдвэрлэгчээс замын тэмдгийг авах ба замын тэмдгийн аливаа захиалгыг үйлдвэрлэгчид өгөхөөс өмнө Инженерт дараах мэдээлэл бүхий бичиг баримтыг хоёр хувь өгч танилцуулсан байна. Үүнд:

- (a) Үйлдвэрлэгчийн нэр, хаяг нийлүүлэх бүтээгдэхүүний тодорхойлолт;
- (b) Бүтээгдэхүүний чанар, зэрэглэл, жин ба баг бөхийн үзүүлэлтүүд бүхий үйлдвэрлэгчийн гэрчилгээ, тодорхойлолт;
- (c) Үйлдвэрлэгчийн Инженерийн зөвшөөрсөн байгууллага буюу лабораторид хийлгэсэн шинжилгээний гэрчилгээ буюу ижил төстэй зүйл төрөл дээр хамгийн сүүлд хийсэн туршилтын дүн;
- (d) Инженерийн зөвшөөрөл авахад үзүүлэх зорилгоор талбайд хураасан тэмдэг, шон ба бэхлэгээний дээж;

Гүйцэтгэгч нь үйлдвэрлэгч буюу ханган нийлүүлэгчээс дараах мэдээллийг гаргуулан авч Инженерт өгнө. Үүнд:

- замын тэмдгийг угсрах заавар, байршил буюу ашиглалтад тавигдах хязгаарлалтууд,
- тэмдгийн ашиглалтын ба засвар арчлалтын заавар.

Үйлдвэрлэгч нь бараандаа 1 жилийн баталгааг Инженерийн зөвшөөрсөн маягтаар гаргаж өгнө.

Замын байнгын тэмдгийг гэрэл ойлгодог будгаар будсан байна. Гэрэл ойлгодог будаг нь Хэсэг 200-д заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай бөгөөд Инженерийн зөвшөөрлөөр механик вакуум халаах аргаар будна

Гэрэл ойлгогч материал нь үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу, тэмдгийн самбарыг тунгалаг лакаар өнгөлсөн байна.

Замын байнгын тэмдгийн хүрээ рам, шон ба бэхлэгээний урьдчилсан будалт болон хамгаалалтын будгийн чанар нь BS 873 стандартын Хэсэг 2, 6 ба 7-д заасан чанарын шаардлагыг хангасан байна. Өөрөөр зааварчлаагүй бол шон, рам, бэхлэгээ болон тэмдгийн арыг саарал өнгөөр будаж өнгөлсөн байна. Тэмдгийг угсарсны дараа боолт болон гайкийг алдагдахаас сэргийлж цэгэн гагнуураар гагнаж бэхлэх ба гагнаасыг саарал өнгийн эпокси цавуутай будгаар будсан байна.

Суулгасан тэмдэг тэгш, тэмдэгийн өнгө үг үсэг ойлгомжтой, нэгэн жигд өнгөтэй, шөнийн гэрэлд жигд бус, сүүдэртэж харагддаггүй байх.

Гүйцэтгэгч нь замын тэмдгийн нүхийг ухаж В 20 маркийн бетоныг нүхний ёроол руу болон шонг тойруулан цутгана. Ухалтаас гарсан материалыг буцааж булна. Эдгээр ажлыг зурагт заасны дагуу буюу Инженерийн зааснаар гүйцэтгэнэ. Тэмдгийн суурийн 5м² -аас дээш талбайтай нүхийг Инженерт үзүүлж зөвшөөрөл авахаас нааш буцааж булахгүй.

Замын тэмдгийн гэрэл ойлгогч гөлгөр гадаргуутай цагаан болон бусад өнгөөр будсан нимгэн үеэс тогтох бөгөөд бүрэн гадаргуугаар гэрэл ойлгох шинж чанартай байна..

Өнгө үл алдах байдал - Тодорхой зохиомол цаг уурын туршилтын дараа сорьц нь MNS ASTM D 4956 : 2005 стандартын 10-р хүснэгтийн шаардлагуудыг хангах ёстой.

Агшилт - Туршилтыг 23±2°C температурт 50±5% харьцангуй чийгшилтэй орчинд 24 цагийн турш байлгана. 229x229мм хэмжээний гэрэл ойлгогчийг 1 цагаас багагүй хугацаанд хамгаалалтын хальстай байлгана. Хамгаалалтын хальсыг хуулж, гэрэл ойлгогчийг хавтгай гадаргуу дээр дээш нь (наалдах арыг дээш харуулж) харуулж байрлуулна. Хамгаалалтын хальсыг хуулсаны дараахь 10мин болон 24 цагийн дараахь 2 сорцын хэмжээг авч хэмжээсийн өөрчлөлтийг тодорхойлно.


Уян хатан чанар - Нугалаасны зузаан нь 3.2мм байхаар бэлтгэсэн хавтгай хатуу биетэд гэрэл ойлгогчийг наалдах хэсгээр нь 1 секундын дотор дарж нугална. Туршихад хялбар байх үүднээс гэрэл ойлгогчийн наалдах ар дээр талкин нунтаг цацаж хавтгай биет наалдахаас сэргийлнэ. Туршилтын сорьц нь 70x229мм хэмжээтэй, турших температур 23±2 байна.

Хамгаалалтын хальсыг хуулах - Хамгаалалтын хальсыг 17.2кПа ачаан доор 71°C-ийн хэмд 4 цагийн турш эрчимтэй хадгалахад амархан салж байх ёстой. Тэмдэгийн хальс наахдаа хөндлөн чиглэлд залгаас үүсгэх ёсгүй.

Цохилт даах чадвар - Туршилтыг 23±2°C температурт 50±5% харьцангуй чийгшилтэй орчинд байлгасан 76x127x1.016мм хэмжээтэй 6061-T6 тэгшхэн гөлгөр гадаргуутай хөнгөн цагаан туршилтын самбарт гэрэл ойлгогчийг наана. 0.91 кг жинтэй 15.8мм-ийн диаметртэй дугуй үзүүртэй ачааг гэрэл ойлгогч дээр 11.5см-кг хүчтэй цохилт үзүүлэх өндрөөс унагаана.

Гүйцэтгэгч замын тэмдгийн үзэгдэх орчинг хангахын тулд ойр хавийн бут, ургамлыг тайрахаас гадна тэмдгийн орчимд материал овоолж буулгахыг зөвшөөрөхгүй.


Гүйцэтгэгч баталгаат засварын гэрчилгээг гаргах хүртэл бүх тэмдгүүдийг арчилж, цэвэр байлгах ба хугарсан, гэмтсэн тохиолдолд шон болон тэмдгийг сольж байна.

 <p>Хот төлөвлөлт, судалгааны институт ЭТ 19-507/10</p>	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД УУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН УУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ						
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА		Масштаб: М1:500	
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор			Үе шат	Хуудас
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24		А3	17
	Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-...		2024 он	

УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ

Хүснэгт 16-1. Байнгын тэмдэгүүдэд тавигдах ерөнхий шаардлага

№	Шалгах үзүүлэлт	Тогтоосон утга буюу хүлцэх алдаа	Шалгах арга ба давтамж
1	Тэмдэгийн гадаад хэмжээс (мм)	Хажуугийн урт нь 1.2м-ээс их үед ± 5 , зөвшөөрөгдөх хазайлт нь хажуугийн уртын $\pm 0.5\%$, гурвалжин дотоод өнцөг нь $60^\circ \pm 5$ байна	Төмөр метр, универсал өнцөг хэмжигч, зузаан хэмжигч: 100% шалгана
2	Тэмдэгийн доод ирмэгээс замын хучлага хүртлэх цэвэр өндөр ба тэмдэгийн дотоод өнцөг ба замын өнцөг хоорондын зай (мм)	+100	Нивлер, хуваарьт уртын хэмжүүр : толгойн хоёр хэсэгт шалгах ба дунд хэсгийн 1-2 хэсэгт утас татаж хэмжинэ
3	Баганын эгц байдал (мм/м)	± 3	Босоо шугам, шугам 100% шалгана
4	Тэмдэгийн төмөр бүрэлдхүүн хэсгийн бүрээсийн зузаан (цм)	Тэмдэгийн багана ба дам нуруу ≥ 78 , бэхэлгээ ≥ 50	Зузаан хэмжигч: 100% шалгана
5	Тэмдэгийн суурийн хэмжээс (мм)	+50, +100	Төмөр шугам, шугам: 100% шалгана

 Хот төлөвлөлт, судалгааны институт 3Т 19-507/10	УЛААНБААТАР ХОТ. ДОРЖИЙН ГУДАМЖНЫ АВТО ЗАМ (САНСАРЫН АЮУЛГҮЙН ТОЙРООС ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОЙД ЧУЛЗВАР, ЦАЙЗ ЗАХЫН ЧУЛЗВАР) АВТО ЗАМЫН ХЭСЭГЧИЛСЭН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ			
	Хэлтс. дарга	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА
	Инженер	<i>Г. Болор</i>	Г. Болор	
	Гүйцэтгэсэн	<i>Э. Өнөмөнх</i>	Э. Өнөмөнх	ЕГ шифр: ХТСИ - 10/24
Шалгасан	<i>С. Анхбаяр</i>	С. Анхбаяр	ТГ шифр: ...-...	
				Масштаб: М1:500
				Үе шат
				Хуудас
				Бүх хуудас
				А3 18 18
				2024 он